



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 1/90

Баян-Өндөр сум

### Гэрийн эргэлтэд шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь заалт, төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам, заавар батлах тухай” А/373 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2021 оны “Амьсгалын замын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/616 тоот захирамж, Томуу, томуу төст өвчний хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх, зохион байгуулах ажлын хэсгийн IV хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Улирлын томуу, томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээ (УТТЦХҮ)-ээр томуу, томуу төст өвчний тархалт “Алаг цоог дэгдэлт”-ийн түвшинд хүрсэн тул 2024 оны 11 сарын 18-ны өдрөөс эхлэн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 5 хүртэлх насын хүүхэд, жирэмсэн эх, 65-аас дээш насын иргэд, архаг хууч өвчтэй, эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг гэрийн эргэлтэд шилжүүлсүгэй.
- Гэрийн эргэлтийн мэдээ тайлан авах маягыг нэгдүгээр хавсралтаар баталсугай .
- Томуу, томуу төст өвчний тархалтын үе шатанд тохирсон бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн ажиллахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн (П.Хишгээ)-д даалгасугай.

ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ



Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны  
11. сарын 19-ны өдрийн дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

9043446 2020030036

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕИЙН СӨЭМТ-ИН АМБУЛАТОРИЙН  
ҮЗЛЭГ